

Ш.Ганхуяг

Философийн тэнхимийн  
багш, Ph.D

### МЕТАФИЗИКИЙН ТУХАЙ ГЕГЕЛИЙН ҮЗЭЛ

**Түлхүүр үг:** диалектик, онтологи, Кант, субъектив логик, объектив логик, адилсал, ялгаа, зөрчил.

**Товч утга:** Метафизикийг цэвэр ахуйн тухай шинжлэх ухаан гэсэн ойлголтоос танин мэдэхүйн арга болгосныг Гегель дахин нягталж шинэ метафизик буюу диалектикийг боловсруулсан нь метафизикийг няцаасан биш, харин дахин чанарын шинэ түвшинд хөгжүүлсэн хэрэг юм.

Гегелээс өмнө метафизик гэсэн ойлголтыг хүмүүсийн мэдрэхүйд өгөгддөггүй ахуйн тийм дээд үнэмлэхүй зарчмын тухай, цэвэр ахуйн тухай анхдагч шинжлэх ухаан гэсэн Аристотелийн анх дэвшүүлэн тавьсан утгаар хэрэглэж ирсэн байдаг. Ахуйн дээд үнэмлэхүй зарчмыг дундад зууны философид бурхнаар төлөөлүүлж ойлгож байв. Харин шинэ үед ахуйн тухай метафизикийг танин мэдэхүйн тухай метафизик болгон хувиргасан билээ. Кант оюун бодрол ба оюун ухаан хоёрыг ялгаатай хэмээн үндэслэснээрээ метафизикийг зөвхөн оюун бодролын арга болгосон өмнөх үеийн философийг шүүмжлэн няцаахад хүргэжээ. Гегель ахуйг ч, танин мэдэхүйг ч тасралтгүй үргэлжлэх үйл явц болгон, үнэн гэдгийг зайлшгүй зөрчлөөр нөхцөлдөгч оюун ухааны хөгжил гэж үзсэнээрээ метафизикийн оронд зөрчлийг ухаарагч диалектикийг оюун ухааны арга болгосон юм.

Гэхдээ Гегель “Логикийн шинжлэх ухаан” зохиолынхоо анхны хэвлэлтэд зориулж бичсэн өмнөх үгэндээ: “Төр эрх, түүний итгэл үнэмшил, ёс суртахууны дадал заншил, сайн үйлс нь ард түмэнд хэрэггүй болсон бол хэр хачирхалтай байх вэ, түүнтэй адил ард түмэн өөрийнхөө метафизикийг алдах юм бол, өөрийнхөө цэвэр мөн чанарыг авч үзэж байгаа оюун санаа аль эрт өөр дотроо бодитой оршихоо байсан бол тэр хэмжээгээр хачирхалтай байх болно”<sup>1</sup> хэмээсэн нь метафизикийн оршин байх зайлшгүй мөн чанарыг түүний үгүйсгэлтэй нэгэн зэрэг хүлээн зөвшөөрсөн хэрэг болно.

Гегелээс өмнөх үеийн философичид логикийг сэтгэхүйн субъектив хэлбэрийн тухай буюу хүний сэтгэхүйн тухай шинжлэх ухаан гэж ойлгож байв. Гегель субъектив логикийг объектив логикоор сольсон бөгөөд “объектив логик нь өмнөх үеийн зөвхөн сэтгэхүйгээр босох шинжлэх ухааны өргөө ертөнцийн орой дээр өлгөгдсөг байдаг

<sup>1</sup> Г.В.Ф.Гегель. Наука логики. М.1999. х.3.

метафизикийн байр суурийг илүүтэй илэрхийлнэ”<sup>2</sup> хэмээн тэрээр өгүүлжээ. Түүний үзлээр логик нь зөв сэтгэхүйн энгийн хэлбэр ба хууль зүй тогтлыг авч үздэг хэлбэрийн логик байх ёсгүй, харин танин мэдэхүйн хөгжлийн ерөнхий түгээмэл хууль зүй тогтлын тухай объектив шинжлэх ухаан байх ёстой. Хэрвээ метафизик нь анхдагч шинжлэх ухаан юм бол зөвхөн объектив логикийн хүрээнд, бүх юмс үзэгдлийн түгээмэл мөн чанарын тухай сургаал байсан цагт л энэ үүргийг гүйцэтгэж чадна гэж Гегель үзсэн байна.

Метафизик нь бүхний түгээмэл үндсийг хөдөлбөргүй тогтоох аваас буруудна, харин бодит ертөнцийг хөгжилд нь авч үзэх ёстой. Энэ тохиолдолд метафизикийн байр суурин дээр диалектик гарч ирэх юм. “... Метафизикийн философичлол, түүний дотроос шүүмжлэлт философичлолын мэдлэггүй ялгавар, диалектик хөгжилд холбоотой ялгавар нь метафизикийн дутагдал юм ...”<sup>3</sup>.

Гэхдээ Гегель диалектикийг метафизикт сөргүүлэн тавихаасаа илүү метафизикийн талаархи шинэ үеийнхний ойлголтыг няцааж, уламжлалт ойлголтыг шинэ түвшинд сэргээн гаргасан байдаг. “Логикийн шинжлэх ухаан” зохиолынхоо оршилд: “... өмнөх үеийн метафизик нь сэтгэхүйн тухай шинэ үед улиг болсон ойлголтоос илүү дээд ариун ойлголттой байсан... Энэхүү метафизикт сэтгэхүй ба сэтгэхүйн тодорхойлолтыг юмст ангид зүйл биш гэж үзэж байсан юм”<sup>4</sup> хэмээжээ. Өөрөөр хэлбэл метафизик бол зөвхөн сэтгэхүйн тухай сургаал биш, түүний хүрээнд ертөнц бүхэлдээ хамрагдах ёстой. Гэхдээ энэхүү ертөнцийг багтаасан метафизикийг XVIII зууны германы философичид анх дэвшүүлж байгаа бус, бүр өмнөх үеийн философичдын үзэлд хадгалагдсаар байсныг Гегель тэмдэглэсэн байдаг. Тэрээр “бүхлийн харилцан тодорхойлогч холбоог илэрхийлж буй метафизик нь мөн чанарын үүднээс бол нэг тоос л устгагдах юм бол бүх орчлон ертөнц нурах байсан гэсэн давтагдмал баталгааг гарган тавьж чадах юм”<sup>5</sup> гэжээ. Энд бүхэл нэгдмэл байдлын цаадах үнэн уг мөн чанарыг гаргавал тэр нь зөвхөн танин мэдэхүй төдийгүй, түүний объект, ертөнц, онтологийн асуудлыг нэгэн зэрэг дэвшүүлэн тавихаас өөр аргагүй гэсэн санаа агуулагдаж байна. Харин аливаа бүхэл нэгдмэл байдлыг ямар нэг олонлогийн нэгдэл гэж үзэх нь зөвхөн шинэ үеийн метафизикт л хамааралтай үзэл бөгөөд үүнийг онолын үүднээс няцааж болно. “Цаг хугацаа нь цагийн тусгаар агшнуудаас, ерөөсөө орон зай нь буюу юуны өмнө шугам нь орон зайн цэгүүдээс, гадар талбай нь шугамуудаас, бүх орон зай гадар талбайнуудаас гэж үздэг метафизикийг математик няцаадаг ...”<sup>6</sup>.

Гегелийн диалектик бий болсноор ерөөсөө метафизик нуран унасан гэж үзэж болохгүй. Учир нь метафизик гэдэг нь шинэ үеийн

<sup>2</sup> мөн тэнд. х.47

<sup>3</sup> мөн тэнд. х.113

<sup>4</sup> мөн тэнд. х.26

<sup>5</sup> мөн тэнд. х.72

<sup>6</sup> мөн тэнд. х.191

философичдын танин мэдэхүйн сургаалд л өрөөсгөл болсноос бус, ерөнхий философийг илэрхийлж байгаа цагт түүний байр суурь алдагдах ёсгүй билээ. Шинэ үеийн танин мэдэхүйн онолыг шүүмжилж Гегель бичихдээ: “Шинжлэх ухаан ба хүн төрөлхтний эрүүл сэтгэлгээ нь метафизикийг нураахад хүргэсэн бөгөөд тэдгээрийн хамтын хүчин чармайлтын үр дүнд *метафизикгүй, боловсролтой ард түмэн* нь ариун шүтээнгүй мөртлөө янз бүрийн чимэг зүүлттэй сүм дуган мэт хачин сонирхолтой дүр зургийг үүсгэсэн билээ. Урьд цагт (үнэндээ хязгаарлагдмал) метафизикийн эрүүл саруул далд нууцыг хадгалан хамгаалагч болж байсан шашны номлол нь энэхүү шинжлэх ухаанаас татгалзаж, түүнийг мэдрэхүй болон хэрэг дээрээ бүх нийтэд хүртээлтэй номлол айлдал, эрдэмтүүхийн мэдлэгээр сольсон юм”<sup>7</sup>. Гегель дундад зууны шашны философи нь метафизикийг шинэ үеийнхнээс илүү илэрхийлнэ хэмээн түүнийг шинэ үеийн философиос илүүд үзэж байжээ. Гегелийн үзлээр дундад зууны философи нь “... метафизик буюу цэвэр эрүүл саруул философийг бүрдүүлэгч логикийн шинжлэх ухааныг өнөөг хүртэл хамгийн ихээр нандигнан хамгаалж байна”<sup>8</sup>. Дундад зууны философи нь байгаль шинжлэлийн буюу эмпирик шинжлэх ухааны аргаас сэтгэхүйн логикийг илүү үндэслэгээ болгодгоороо шинэ үеийн философиос давуу юм гэж Гегель үзжээ. “Хэрвээ ... христос шашны метафизик нь юу ч үгүйгээс юу ч үүсэн гарахгүй гэдгийг няцаасан бол, үүгээрээ тэрээр ямар нэг юм хамгийн сүүлчийн байдалдаа хүрсэн ч, синтезийн ч бай, эсвэл ердийн төсөөллийн хэлбэртэй ч бай, тэр бүү хэл хамгийн боловсронгуй бус холбоосондоо ч ахуй болон ямар нэг юм хоёр уулзалдаж, ялгаа нь арилдаг тийм цэг олдоно гэдгийг баталсан юм”<sup>9</sup>.

Түүнээс гадна Кантын трансценденталь философид логикийг метафизикийн утга агуулгаас нь салгаж авч үздэг болохыг Гегель шүүмжилсэн байдаг<sup>10</sup>. Үнэн хэрэгтээ шинэ үеийн философи болон Кантын философийн хооронд зарчмын ялгаагүй гэж Гегель үзжээ. Түүний үзлээр шинэ үеийн философид “юмсыг метафизикийн үүднээс тодорхойлох [хандлага] нь өөрөө ч, өөрийнхөө тодорхойлолтоор ч туршлагын хүрээнд хамаарагддаг бөгөөд нэг талаас, [энэхүү хандлага нь] ойлголт гаргах оролдлого болохын хувьд шинэ байгалийн философи, байгалийн шинжлэх ухааны үндсийг хүртэхүйд өгөгдсөн ямар нэг мэдрэмж болгож, түүний тодорхойлолтуудыг хийсвэр ойлголтоос гарган мэддэг философид түлхэц өгсөн болохоор гайхамшигтай, нөгөө талаас, Кантын зохиосон бүтцээс хальж гаралгүй түүнийг философийн эхлэл бөгөөд физикийн үндэс гэж үздэгээрээ сонирхолтой билээ”<sup>11</sup>.

<sup>7</sup> мөн тэнд. х.4

<sup>8</sup> мөн тэнд. х.6

<sup>9</sup> мөн тэнд. х.70

<sup>10</sup> мөн тэнд. х.28

<sup>11</sup> мөн тэнд. х.180

Гегель адилслыг зөрчил болтол нь хөгжүүлснээрээ Кантын философиос даван гарсан байдаг. "Байх ёстой зохилдол гэдэг нь өөртөө-байгаа-ахуй буюу өөртэйгээ зохицохуй болон тодорхойлогдох чанар буюу хязгаар гэсэн утгаар сүүлийн үеийн философид, ялангуяа ёс суртахуунтай холбоотой асуудалд, мөн метафизикт их үүрэг гүйцэтгэж байгаа юм"<sup>12</sup>. Өөрөөр хэлбэл, Кантын философи нь шинэ үеийн метафизикийн аргаас бүхэн ангижирч чадаагүйг энд тэмдэглэсэн хэрэг болно.

Адилсал ба ялгаа нь тус тусдаа байх саланги хоёр зүйл биш, харилцан нягт уялдаа холбоотой эсрэг тэсрэг талууд юм гэж үзсэнээрээ Гегель шинэ үеийн метафизикчид болон Кантаас ялгарсан билээ. Ялгаа гэдгээс тусгаарлан авсан цэвэр мөнхийн хийсвар адилслын тухай ярьдаг шинэ үеийнхний метафизикээс Гегелийн тодорхой мөнх бус адилсал нь өөр дотроо ялгаагаа агуулж байдаг юм. "Хувь хүн ч, төгсгөлтэй юмс ч байгаагаараа өөр дотроо, өөртөө зориулж оршино, тодорхойлогдох байдал нь өөрийн мөн чанараараа үгүйсгэл мөн бөгөөд мөнх бус юмс нь оюун бодролын эсрэг хөдөлгөөнийг өөртөө татаж, бүхнийг хийсвэр нэгдэлд нь устадаг гэдгийн эсрэг ахуйн метафизикт хувь хүн гэдгийг бүхлээр нь тодорхойлдог"<sup>13</sup>. Ийнхүү Гегель өөрөө өөртэйгээ зөрчилдөхийг хөгжил гэж, хөгжлийг шинэчлэгдсэн метафизикийн буюу диалектикийн авч үзэх гол зүйл болгожээ.

### Дүгнэлт

Метафизик гэсэн ойлголтыг ахуйн тухай онтологийн сургаал гэх юмуу, диалектикийн эсрэг сэтгэлгээний арга гэж үздэг нь түүнийг хязгаарлагдмал хүрээнд оруулсан хэрэг бөгөөд Гегель метафизикийг философийн бүх асуудлыг нэгтгэн багтааж, байнга тасралтгүй хөгжиж байх ёстой философичлол гэсэн утгаар ойлгож, энэхүү хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах үүднээс философийн сургаалаа боловсруулсан нь түүний зохиол бүтээлээс харагдаж байна.

### Ном зүй:

1. Г.В.Ф.Гегель. Наука логики. М., 1999

<sup>12</sup> мөн тэнд. х.126

<sup>13</sup> мөн тэнд. х.104